

БАЯНГОВЬ СУМ ХЭАХС НИЙГЭМЛЭГ 2024 ОНД
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оын 12 дугаар сарын 01

Өргөн

ЭРХЭМ ХЭРЭГЛЭГЧ ” АЯНЫ хүрээнд хэрэглэгчийн эрхийг хамгаалах салбар нийгмэлэг дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1.Сум орон нутгийн Төрийн захиргааны байгууллага болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг нь хэрэглэгчийн эрхийг сурталчлан таниулах аянд нэгдэж буйгаа илэрхийлж цахимаар эрх үүргийг танилцуулан ажилласан.

2. Хэрэглэгч эрхийг сурталчлан таниулах сургалтын гарын авлага бэлтгэн олон нийтийг хамарсан арга хэмжээний үеэр мэдээллийг хийж ажилласан. Нийт 76 иргэнд гарын авлага тараасан.

Зураг1. Иргэдэд гарын авлага тараах үе



3.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Өрсөлдөөний тухай хуулиар сургалт мэдээллийг хийж ажилласан. Сургалтанд нийт 20 үйлчилгээний байгууллагын ажилтан хамрагдсан. Хяналт шалгалтыг Цагдаа Б.Батмөнх, Татварын улсын байцаагч Ц.Буянжаргалтай хамтран зохион байгуулсан. Энэ үеээр


согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл, бараа бүтээгдэхүүний хугацаа, татварын бүртгэлгүй архины талаар худалдагч байгууллага анхаарууллага зөвлөмжийг өгч ажилласан.



Зураг2.Сургалт

болон


хяналт



шалгалтын

үеийн

зураг



4. Аймгийн ХХАА-н газрын хүнсний чанар аюулгүй байдлыг хариуцсан хяналтын улсын байцаагч Жавзандуламтай хамтарч сумын ХЭАХС нийгэмлэг

Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын ажлын хэсэг хүнсний дэлгүүрүүд, хоол үйлдвэрлэл үйлчилгээний нийт 15 газарт хяналт шалгалтыг хийсэн.

Хяналт шалгалтаар:

- ✓ зах зээлд нийлүүлж байгаа бараа, ажил, үйлчилгээ нь хэрэглэгчийн аюулгүй байдал, тоо, хэмжээ, чанар, хугацаа, зориулалтын зохих шаардлагыг хангаж буй эсэх.
- ✓ Хэрэглэгч нь бараа, ажил, үйлчилгээний талаар үнэн зөв мэдээлэл олж авч буй эсэх.
- ✓ барааны баталгаат болон эдэлгээний хугацаа; зэрэг хуульд заасан заалтуудыг шалгаж үзээд 10 иргэнд торгуулийн арга хэмжээ авч хугацаа дууссан бараа бүтээгдэхүүнийг хураан авч, устгал хийсэн.





Хяналт шалгалт хийх үеийн зураг




4. Сумдын Хүнсний дэлгүүр, супермаркет, зоогийн газар, караоке, үйлчилгээний газрууд нь үйл ажиллагаа явуулахдаа хэрэглэгчийн эрхийг хэрхэн хангаж ажилладаг талаар иргэдээс сэтгэл хангамжийн талаар дэлгүүр бүрт сэтгэл ханамжийн дэвтэрийг байршуулан сэтгэл ханамжийн судалгааг авсан. Нийт 12

дэлгүүр сэтгэл ханамжийн дэвтэр нээж, байнгын үйлчлүүлэгч 78 иргэнээр санал хүсэлт бичүүлсэн байна.


Зураг3. Сэтгэл ханамжийн дэвтэр "Баялаг өлзий" дэлгүүр



Зураг4. Сэтгэл ханамжийн дэвтэр "Тэргүүн богд" дэлгүүр



Зураг3. Сэтгэл ханамжийн дэвтэр "Баялаг өлзий" дэлгүүр



Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үүднээс е-баримтыг олголт анхаарч ажилласан. Сумын хэмжээнд нийт 20 аж нэгж тогтмол үйл ажиллагаа явуулдаг. 12 аж ахуй нэгж нь тогтмол е-баримт гарган үйлчилж байна.

ХЯНАСАН:
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХЭАХСН-ИЙН

ДАРГА